

“СҮРЬЕЭ, ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” ТӨСЛИЙН ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 4-Р ХУРЛЫН ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

Огноо: 2025 оны 2-р сарын 5-ны өдөр

Хугацаа: 12.00-12.45 (УБ), үргэлжлэх хугацаа 45 мин

Хурал болох газар: Эрүүл мэндийн яамны хурлын заал

Хурлын хэлбэр: Танхим болон цахим (Zoom) хосолсон

Хурлын хэл: Монгол-англи (орчуулагч)

Модератор: Л.Баттөр, ЭМЯ-ны НЭМБГ-ын дарга, төслийн захирал

Сэдэв: “Сүрьеэ, ям өвчний хяналт” хамтарсан төслийн хүрээнд зоонозын халдварт өвчний нэгдсэн платформыг бий болгож хөгжүүлэх

Хэлэлцүүлгийн дэг:

- Хариулах хугацаа: 3 мин
- Тодруулга: 1 мин
- Хэлэлцүүлгийн дараа нийт оролцогчдын асуулт, хариулт явуулах хугацаа: 5 мин

Хэлэлцүүлгийн хүрээнд дараах асуудлыг ярилцана:

Панелист:

1. Мияаги Кэнсүкэ, Японы техникийн хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга
2. Сокорро Эскаланте, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч
3. Г.Энхтулга, Цахим хөгжлийн яамны салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч
4. А. Нарантуяа, МЭЕГ-ын дарга, Ерөнхий малын эмч
5. Б.Болдбаатар, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга
6. А.Түвшинбаяр, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга ахлах мэргэжилтэн
7. Ц.Нямхүү, МЭЕГ-ын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикткийн газрын систем администратор (Утас: 89807127, nyamkhuu.ts@vet.gov.mn)
8. Э.Мягмар-Өлзий, ЭМЯ-ны Эрүүл мэндийн мэдээллийн цахим хөгжлийн хэлтсийн дарга
9. Э.Анхбаяр, ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал
10. Б.Батцэцэг, МЭЭШХ-ийн захирал
11. Б.Амгаланбаяр, ЗӨСҮТ-ийн захирал
12. Такаши Кимура, Төслийн удирдагч
13. Ясухихо Сузүки, төслийн зөвлөх

Үндэслэл:

Монгол Улсад “Сүрьеэ, ям өвчний хяналт” төслийг Монгол Улсаас Эрүүл мэндийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Эдийн засгийн хөгжлийн яам болон Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн зэрэг байгууллагууд Япон улсаас

Хоккайдогийн их сургууль, Зооноз судлалын судалгааны төв болон Япон улсын Сүрьеэ судлалын хүрээлэн хамтран 2020-2025 онуудад хэрэгжүүлж байна.

Тус төслийг санхүүжилтийг Япон улсаас Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны байгууллага (JICA), Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн байгууллага (AMED)-ын хамтарсан "Тогтвортой хөгжлийн төлөө шинжлэх ухаан, технологийн судалгааны түншлэл" төсөл (САТРЕПС төсөл)-өөр, Монгол Улсаас БШУЯ, ЭЗХЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар зэрэг байгууллагууд хариуцаж, Монгол Улсаас Сангийн Яам Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь дэмжин, хамтран ажиллаж байна.

Хүн төрөлхтний амьдралын сүүлийн зуу гаруй жилийн хугацаанд бүрэлдэн тогтсон “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн болон мал, амьтны эрүүл мэнд хоорондоо салшгүй холбоотой, харилцан хамааралтай гэдэг үзэл санаанд нэгддэг. Энэхүү үзэл баримтлалын дор дэлхий дахинаа хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль экологид учирч болох эрсдэлийг ойлгож зохицуулах, экосистемийн тогтвортой, тэнцвэрт байдлыг дэмжих нь дэлхий нийтийн хамтын арга хэмжээ юм.

Энэхүү хэрэгжүүлж байгаа САТРЕПС төсөл нь сүрьеэ, ям өвчнийг нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй хянах тогтолцоог Монгол Улсад бүрдүүлэх зорилготой юм.

Монгол болон Япон улсын Засгийн газар хоорондын хамтарсан төсөл нь хочр улсын хооронд харилцан тохиролцож, 2019 оны 10-р сарын 25-ны өдөр байгуулсан төслийг хэрэгжүүлэх “ММ (Minutes of Meeting), R/D (Record and Discussions)”-ийн хүрээнд “Сүрьеэ, ям өвчний хяналт” төсөл хэрэгжүүлж байна.

Хоёр талын санал нийлсэн, нэн чухал ач холбогдол бүхий шийдэл нь төслийн үр дүнд бий болсон шинжлэх ухаан-технологийн үр дүн, инновацийн бүтээгдэхүүн, шинээр байгуулсан лаборатори, тоног төхөөрөмжийг Монгол Улсын холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэж байх, салбар хоорондын болон салбар дотрох хамтын ажиллагааг уялдуулахыг эрмэлзэн ажиллаж байгаа бөгөөд үүнийг төсөл дууссаны дараа ч тогтвортой хадгалан, сайжруулан бэхжүүлэх нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах нь дамжиггүйг илэрхийлсээр байгаа. Энэхүү төслийг 2020 оны 11-р сараас хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2025 оны 10-р сарын 31-ээр дуусах юм.

Тус төслийн хүрээнд бий болгох нэгэн томоохон үр дүн нь Нэг-эрүүл мэнд (One Health) үзэл баримтлалд тулгуурласан “**Зоонозын халдварт өвчнийг хянах**” платформыг Монгол Улсад бий болгох юм. Энэ зорилгын хүрээнд өнөөдрийн хэлэлцүүлэгийг хамтран зохион байгуулж байна.

Зорилго: Нэг-эрүүл мэнд үзэл баримталын хүрээнд салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох, зоонозын халдвар өвчинтэй хамтран тэмцэх “Зооноз өвчинтэй тэмцэх цахим платформ”-ын оновчтой хувилбарыг дэвшүүлэх, бий болгох

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АСУУЛТ ХАРИУЛТ:

Г.Энхтулга, Цахим хөгжлийн яамны салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч

1. Зоонозын өвчнийг олон эх сурвалж ашиглан салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох, эрсдлийн үнэлгээг цахим платформд суурилан хэрэгжүүлэх талаар ямар ажил хийгдэж байгаа вэ? **Хариулт: Г.Энхтулга:**2024 оны жилийн хугацаанд Ерөнхий сайдын захирамжаар ЭМЯ, ЦХХХЯ, ХХЯ хамтарч ажилласан Эрүүл мэндийн салбарын төрөлжсөн мэдээллийн сан Засгийн газрын 2024 оны 100-р тогтоолоор батлагдсан. төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээтэй холбоотой ирж байгаа E-mongolia сан руу гаргасан.Мэдээллийг ашиглах, дамжуулахтай холбоотой хууль эрхзүйн хувьд хангагдсан байгаа. Онцгой байдлын үед ямар цахим мэдээллийн ажлын даалгавар өгөгдөөд явж байгаа. Хамтарсан ажлын хэсэг Зоонозын өвчний эрсдлийн үнэлгээ хийх ажлын даалгавар өгөгдөөд явж байна үүнийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх үүргийг ЦХХХЯ, ЭМЯ үргэлжлүүлэн хэрэгжүүлээд явж байна.

Э.Мягмар-Өлзий дарга, ЭМЯ-ны Цахим хөгжлийн хэлтэсийн дарга

1. Нэг-эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд зоонозын өвчнийг Эрүүл мэндийн нэгдсэн сан (ESB) платформд нэгтгэх боломж байгаа юу? Хэрэв боломж байгаа бол ямар байдлаар нэгтгэж ашиглаж болох вэ?
Хариулт Э.Мягмар-Өлзий дарга:
ЭМ-ийн салбар бие даасан олон олон мэдээллийн сантай байсан. Үүнийг төрөлжсөн байдлаар эрүүл мэндийн бүх тусламж үйлчилгээний мэдээллийг сан нэгтгэгдсэн. Үүндээр зоонозын өвчний мэдээллийн сан хамтарч орох шаардлагатай ба үүн дээр хамтарч ажиллах болно.

Э.Анхбаяр, ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал(дэд захирал О.Батбаяр асуултад хариулав)

1. САТРЕПС төслийн хүрээнд үхрийн сүрьеэ болон адууны ям өвчний тандалтын тогтолцоог бий болгож байна. Үүнийг цаашид урт хугацаанд тогтвортой авч явах ямар бодлого, төлөвлөлт байгаа вэ? Халдварт өвчний нэгдсэн тандалтын цахим платформд нэгтгэх чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа вэ?
2. Тус төслийн хүрээнд сүрьеэгийн илрүүлэлт, оношилгооны чиглэлээр олон шинэ технологи аргуудыг амжилттай нэвтрүүлсэн. Эдгээрийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал засвар үйлчилгээ, урвалж оношлуур зэргийн тасралтгүй ханган нийлүүлэх ямар төлөвлөлт байгаа вэ?

ХӨСҮТ-ийн дэд захирал О.Батбаяр Хариулт 1: САТРЕПС төслийн хүрээнд үхрийн сүрьеэ болон адууны ям өвчний тандалтын тогтолцоог бусад Зоонозын өвчний тандалтын системтэй уялдуулж тогтвортой авч явах хүсэлтэй байгаа. Үүний тулд бид Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв буюу Эрүүл мэндийн салбарын мэдээлэл технологийн төвд байрлах Халдварт өвчний

тандалтын системд холбох улмаар ОБЕГ-т байрлах салбар хоорондын мэдээлэл солилцох платформ-тэй холбогддог тийм тогтолцоог бий болгох төлөвлөгөөтэй байна. Улмаар энэхүү өвчнийг мэдээлэх ёстой өвчний жагсаалтад оруулж батлуулан Салбар хоорондын хариу арга хэмжээтэй уялдуулах мөн NAPHS буюу Эрүүл Мэндийн Аюулгүй Байдлын Үндэсний Стратегийн ажлын төлөвлөгөөнд оруулах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Хариулт 2.

Энэ төслийн хүрээнд манай төвийн Сүрьеэгийн үндэсний лавлах лабораторийн түвшинд сүрьеэгийн халдварыг цусанд илрүүлэх, шинэ эмийн тэсвэржилт илрүүлэх, дараа үеийн геномын бүрэн дараалал тогтоох болон ЛАМП-ийн шинжилгээг нэвтрүүлээд байна. Манай төвийн хэмжээнд зөвхөн энэ САТРЕПС төслөөс гадна олон төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг. Тухайлбал Глобаль сан, БНСУ-ын Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгийн төслийн хүрээнд олон шинэ технологи бүхий орчин лабораторийн болон дүрс оношилгооны тоног төхөөрөмж, арга аргачлал нэвтэрч байна. Үүнийг цаашид тогтвортой байдлыг хангах нэгдсэн төлөвлөлт хийх, улсын төсөвт суулгах, Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулах, өндөр өртөгтэй тусламжийн жагсаалтад оруулах зэрэг ажлуудыг энэ оны эхний хагас жилд багтааж хийхээр ажиллаж байна.

Б.Амгаланбаяр, ЗӨСҮТ-ийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Орломжав дарга орон хариулав

1. Танай төвөөс аймаг, орон нутагт үхрийн сүрьеэ болон адууны ям өвчний тандалтын тогтолцоонд газар дээр нь ажиллаж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх боломж байх уу?
2. Танай төв эдгээр 2 өвчний оношилгооны лабораторийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ямар бодлого байгаа вэ?

Хариулт 1: Орломжав

Төслийн хүрээнд ажиллагчаар оролцсон.

Зоонозын өвчинсудлалын өвчин судлаалын чиглэлээр 14 аймагт салбарт төвтэй тандалтын тогтолцоо бүрэн тогтсон голомтын судалгаа хийхэд аргазүйн дэмжлэг үзүүлж ажилладаг. Ям өвчний хүний тохиолдлын оношийг тодруулахад хамтарч оношийг баталсан.

Хариулт 2. Манай лаборатори геномын дараалал тогтоох шинжилгээ хийх чадавх бүрдсэн. Өнөө жилээс геномын дараалал тогтоох шинжилгээ хийж эхлээд байна. 14 аймаг молекулын лабораторитой болж байгаа.

А.Нарантуяа, МЭЕГ-ын дарга, Ерөнхий малын эмч, **Б.Болдбаатар**, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга, **А.Түвшинбаяр**, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга ахлах мэргэжилтэн, **Ц.Нямхүү**, МЭЕГ-ын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистиктэй газрын систем администратор

1. Зоонозын халдварт өвчний үед харилцан мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд, тухайлбал адууны ям өвчний тохиолдолд хүн эмнэлэгт мэдээллийн шуурхай солилцоход ямар бэрхшээл байна вэ?
2. Үүнийг цаашид сайжруулахад ямар арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?
3. Цахим платформд суурилан хэрэгжүүлэх боломж байгаа юу?
4. Нэг-эрүүл мэндийн үзэл баримтлалын хүрээнд зоонозын халдварт өвчний төлөв байдлын мэдээ, мэдээлэл солилцох, өвчний тандалтыг хамтран хэрэгжүүлэх, тохиолдын үед шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, мэргэжилтэний нөөцийг оновчтой ашиглах, эрсдэлт хүчин зүйлсийг таслахад хамтран ажиллах, лабораторийн чадавхыг бэхжүүлэх, хамтран ашиглах чиглэлээр ямар ажил төлөвлөж байгаа вэ?

Хариулт (асуулт 1-4) Б.Болдбаатар, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга: Мал амьтны хууль батлагдасанаас 2017 онд батлагдснаас хойш нэг сайн заалт орсон байдаг. Салбар дундын зөвлөл ажиллуулах энэ маань урагштай явахгүй байна. Зоонозын өвчний мэдээллийг салбар хооронд солилцох гэсэн заалт байдаг хэрэгжилт төдийлөн хангалтгүй байдаг. Зоонозын өвчний мэдээлэл нэг түвшинд нэг мэдээлэлтэй болж чадахгүй байна Мэдээлэл солилцох дээр хойрго байгаа. Салбарын байгууллагыг холбох ажил хангалтгүй. Манай мал эмнэлгийн салбар мэдээллийн системд бүртгэлээ 2020 оноос хойш хийж чадсан. Системийн хөгжүүлэлтийн стратегийг бий болгож цаашдаа их өгөгдөл дээр суурилан дүн шинжилгээ хийх платформыг ажиллуулахаар төлөвлөж байна. Германы засгийн газрын санхүүжилттэй “Байгалд ээлтэй нэг эрүүл мэнд” төслийн хүрээнд Салбар дундын платформ ажиллуулж их өгөгдөл суурилан дата анализ хийдэг тооцооллын платформтой болох зорилт тавьж мэдээллийг филтэртэй хүлээж авч дүн шинжилгээ хийдэг болохоор төлөвлөж байна. шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх дээр түр хойшилсон Америкийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлэх шуурхай хариу арга хэмжээний тогтолцоог хөгжүүлэх төсөл хэрэгжих хугацаа хойшилсон байгаа цаашдаа хэрэгжин гэж найдаж байна.

Ц.Нямхүү, МЭЕГ-ын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын систем администратор : Мал эмнэлгийн салбарын мэдээллийн технолги, мэдээллийн аюулгүй байдлын стратегитай болж байгаа. Дижитал шилжилт буюу шинэлэг технологийг нэвтрүүлэлт хэрэглэлт ордог. Бүртгэлийн системийг шинэ технологи ашиглан хэрхэн хөгжүүлэх талаар стратеги гарсан шинэ технологийг хэрхэн нэвтрүүлэх бэ гэдэг дараагийн 5 жилийн төлөвлгөө гарч байна. Салбар дундын нэг эрүүлмэнд платформ хөгжүүлье гэвэл хэрэгжүүлэх процесс дроцедурыг тодорхой болгох, үүнээс цааш нь платформ хөгжүүлэх нь мэргэжлийн хүмүүсийн хийх ажил. Мэргэжлийн хүмүүс мэдээлэл солилцох дээр тохирсон байх ёстой. Дата анализ хийх хүмүүс цааш нь тогтмол ажиллана. 3 талд мэдээллийн тогтолцоо бүртгэгдсэн тхиолдолд дүн шинжилгээ хийх боломжийн ба цаашид

тогтвортой ажиллуулахад дата анализын цалинг тогтвортой авч явах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.Харьцангуй хэрэгжүүлэхэд дөхүү болсон байгаа.

Хариулт А.Түвшинбаяр, МЭЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга ахлах мэргэжилтэн Төслийн хүрээнд мэдээлэл солилцож салбарын хүрээнд болж байна.

Бусад ЗӨСҮТ дээр мал амьтны эрүүл мэндийн хуулин дээр хэрэгждэггүй 3 заалт байдаг, дэд сайд ахлахаар байгаа дэд сайд байхгүй болсо болохоор үүнийг солих. Мэдээлэл солилцох, хэн тэргүүлэх талаар заасан байдаг. Стратеги төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлэх ажил эхлээч үгүй байгаа. Хууль эрхзүйн орчинд заасан заалтыг холбочихбол энэ үйл ажиллагаа хэрэгжих боломжтой.

Б.Болдбаатар Зооноз өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай үүний дэмжээ төслийн зүгээс явбал хэрэгтэй байна. Мэдээлэл солилцдог салбар дунд зохицуулалт хийвэл дээр байна эн төсөл үр дүнгээ өгнө, нэг төлөв дээр өвчнөө үнэлдэг, мэддэг байх талаас төсөл дэмжлэг үзүүлнэ гэж найдаж байна.

Сокорро Эскаланте, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч

1. Эрүүл мэндийн аюулгүй байдлын үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (National Action Plan of Health Security) дээр адууны ям өвчин ба зоонозын өвчнүүдийн дэгдэлт ба хариу арга хэмжээг салбар хоорондын мэдээллийн солилцоог хэрхэн хангаж ажиллах вэ?

Хариулт Сокорро Эскаланте, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч

Энэ асуултаас илүү зүйлийг яримаар байна. Нэг эрүүл мэндийн үзэл баримтлалын тухайд ямар байр суурьтай байгаагаа ярья. Олон байгууллагаа оролцож нэг эрүүл мэндийг бий болгох талаар хичээнгүйлэн зүтгэж байна. Олон улсын хамтын нийгэмлэг дэмжижи байна. Нэг эрүүл мэндийг уялдаатай хэрэгжүүлж чадахгүй байна. Сүүлийн 2 жилд миний хувьд энэ чиглэлээр илүү ажиллаж байна. Өөрийн саналыг хэлье. ДЭМБ, ДМАЭМБ хамтран Нэг эрүүл мэндийн бичиг албан шийдвэр гаргах нь зүйтэй. Хэлэлцүүлэг бүхэлдээ нэг эрүүл мэндийн үзэл баримтлалд суурилсан байна. Мэдээллийн сан, цахим сан гэж их ярьж байна. Бодит байдлыг үнэлэх хэрэгтэй байна. Ямар төрлийн мэдээллийг яаж цуглуулах вэ гэдэгтээ анхаарах хэрэгтэй. Ямар платформ ямар бүтэцтэй нэг тогтолцоо байлаач гэсэн эрүүл зөвхөн нэг систем байна гэдэг нь боломжгүй. Цахим шилжилт засгийн газраас хийж байгаа нэг том ажил. Мэдээлэл цуглуулах ажиллагааг түргэвчил өгөх ажиллагаа.Бид цахим шилжилтийг бүрэн дэмжиж байна. Цахим шилжилтийг дэмждэг ч тандалтын мэдээллийг шууд харах боломжгүй. Тандалтын талаар ярья. Үүнийг үнэлэх хэрэгтэй.

Тодорхой шинжлэх ухаантай тодорхой аргатай, тандалтын тогтолцоог хэрхэн нэгтгэх бэ зөв хүмүүс зөв шийдвэрийг зөв цагт нь гаргах хэрэгтэй. Платформ өвөрмөц байх ёстой. Дижитал бүтэц, өвөрмөц талбарт өвөрмөцөөр хэрэгжинэ. Ямар төрлийн датаг ямар чиглэлээр цуглуулах хэрэгтэй болно.Нэг удаагийн хэлэлцүүлгээр шийдэх боломжгүй олон удаа хэлэлцэх хэрэгтэй болно. Одоогийн дэд бүтэцээ хараад яаж нэгтгэх яаж хэрэглэх,

юунд хэрэглэх вэ гэдэг дээр бодох хэрэгтэй. Мал эмнэлэг, хүн эмнэдгийн дата нэг платформд гэтгэн гэдэг нь төвөгтэй ажил. Жайка хүний нөөц, аргачлалын хувьд дэмжлэг үзүүлж байгаад байна. Нянгийн тэсвэржилтэн дээр үүнийг үзэж байна. Цахим шилжилт тодорхой байх. Малын эрүүл мэндийн нэгдсэн систем хүн малын эрүүл мэндийн тогтолцоо яаж холбох, үр дүнтэйгээр мэдээлэл солилцох онцгоо анхаарах хэрэгтэй.

Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хөндлөнгийн үнэлгээгээр дүгнэж үр днг гаргасан байгаа. Эхний хэсэг нь сэргийлэлт хэрхэн хийх, лабораторийн чадавхи мал амьтны эрүүлмэндийн салбарт юу байгаа, хүний эрүүлмэндийн

Онцгой байдлын бэдлэн байдал хариу арга хэмжээ авч чадах нөхцөл рүүгээ хир хурдан шилжижи чадаж байгаа нь чухал юм. Шуурхай удирдлагын төв ЭМЯ –ны А зааланд байршуулна. ХӨСҮТ, ЗӨСҮТ датагаа шуурхай удирдлагыг төв рүү өгнө. Байгууллагууд эхний дүн шинжилгээгээ өөрсдөө хийчихсэн байх ёстой. Дараа дараадаа ийм уулзалт хийж асуудлыг шийдвэрлэх нь чухал байна.

Б.Батцэцэг, МЭЭШХ-ийн захирал

1. САТРЕПС төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үхрийн сүрьеэ, адууны ям өвчний тандалт, оношлогооны чадварыг сайжруулах, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ололттой, эерэг үр дүнг цаашид хэвээр хадаглах, салбар хоорондын хамтын ажиллагаа (ХӨСҮТ болон МЭЭШХ хоорондын хамтын ажиллагаа)-г эрчимжүүлэхийг зорьж байна. Үүнийг цаашид урт хугацаанд тогтвортой авч явах ямар бодлого, төлөвлөлт байгаа вэ?
2. Тус 2 байгууллага нь зоонозын халдварт өвчний нэгдсэн тандалт (тухайлбал ям өвчин), өвчинтэй тэмцэх цахим платформд нэгдэх чиглэлээр ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ?
3. Тус САТРЕПС төслийн хүрээнд үхрийн сүрьеэ, адууны ям өвчний оношилгооны чиглэлээр шинэ технологи, оношлогооны аргуудыг амжилттай нэвтрүүлсэн. Эдгээрийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал багаж, тоног төхөөрмөжийн засвар үйлчилгээ, шаардлагатай бодис, урвалж оношлуураар тасралтгүй хангахад ямар бодлого, төлөвлөлтийг барьж ажиллах вэ?
4. Тус САТРЕПС төслийн хүрээнд байгуулсан “Биоаюулгүй ажиллагааны 3 дугаар зэрэглэл”-ын лабораторийг салбар хооронд хамтран ашиглах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд ямар бодлого баримтлах вэ?

Хариулт Б.Батцэцэг, МЭЭШХ-ийн захирал

Малын эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийж байна. хариулт давхцахаар асуулт байна. Хүн малын салбарын хамтын ажиллагаатай амжилттай хэрэгжиж байгаа төсөл гэж үзэж байна. Жайка болон АМЕД байгууллагад талархаж байна. Зөвлөхүүд болон судлаачид сэтгэл нийлж зүтгэж ажиллаж байгаад талархаж байна. Тодорхой өвчнүүд дээр хамтын ажиллагааны санам байгууллаад хамтарч ажилах нь зүйтэй. РЗ лаборатори төслийн

хүрээнд Монгол талд оруулсан том хувь нэмэр юм. Үүнийг үр ашигтай ашиглах нь чухал юм. Манай лабораторийг нянсудлалын шинжилгээнд хамтарч ашиглаж болно. Мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчинд нээлттэй. Лабораторийн засвар үйлчилгээний тал дээр жил болгоны төсөвт суулгаж явах хэрэгтэй байна. Нилээд зардалтай болно. Жайка талаас Follow-up програм байдаг энэ талаас эхний жилүүдэд туслах боломж байвал сайн байна. Энэ хүсэлтийг Жайкад тавихыг хүсэж байна.

Оношилгооны аргуудын хувьд мал эмнэлгийн ерөнхий газартай хамтраад бүртгэлд оруулна. Төрийн худалдан авалтаар худалдан авахаар санал тавина.

Мияаги Кэнсүкэ, Японы техникийн хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга

Асуулт

Юун түрүүн Японы татвар төлөгчдийн мөнгөөр энэ төслийг хэрэгжүүлсэнд талархаж байна. Төслийн талаар хуралд оролцогчдод саналаа хэлнэ үү гэж хүсэж байна. Мөн бруцеллезийн өвчинтэй тэмцэх шинэ төслийг ярьж байгаа энэ төсөл дээр танай талаас дэмжлэг үзүүлнэ гэж бид найдаж байгаа.

Хариулт Мияаги Кэнсүкэ:

Та бүхнийг манай өнөөдрийн хуралд оролцож идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлж байгаад талархлаа. Өнөөг хүртэл төсөл хамтран оролцож төсөл хэрэгжүүлсэн оролцогч талуудад талархал илэрхийлье. Та бүхний хүчин чармайлтаар өнөөдрийн хуралд танилцуулсан үр дүн гараад дуусах шатруу явж байна. Асуултад хариулахаас өмнө дараагийн шатны төслийн тухайд хариу хараахан гараагүй байгаа. ДЭМБ-ын доктор Соккоро чухал санал зөвлөмж хэллээ. Үүнтэй санал нэгдэж байна. Мэдээж ДЭМБ-ын зүгээс Монгол улсад нэг эрүүлмэндийн нэгдсэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд өндөр түвшний байгууллагууд бодлого шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ёстой гэж ярьж байна. Мал хүний өвчний шинжлэх ухааны нотолгоонд суурилан платформ хэрэгжүүлэх зорилго тавьж үр дүнд хүрч байна. МЭХ, ХӨСҮТ мал амьтны болон хүний өвчин судалдаг байгууллагууд маань төслийн хүрээнд хамтарч судалгаа хийж аргачлал гарган мэргэжлтнээ сургаад хамтарч ажиллаад сурлаа. Нэг эрүүл мэнд гэдэг том тогтолцоо руу хэрхэн ойртуулах вэ гэдэг дээр анхаарч нэгэнт бий болсон үйл ажиллагааг цаашид тогтвортой авч явах, байнгын ажиллагаатай байгаасай. Мал хүний өвчнийг шинэ аргачлалд тулгуурлан хөгжүүлж, цаашид тогтвортойгоор, хөгжүүлж авч явах байх гэж бодож байна.

Заавал сайдын тушаал шийдвэр гэхгүйгээр тогтсон үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаасай гэж бид хүсэж байна.

Такаши Кимүра, Төслийн удирдагч, Хоккайдо их сургуулийн мал эмнэлгийн факультет эмнэлзүйн шинжлэх ухааны эмгэг судлалын лабораторийн профессор

1. Та Монголд энэхүү төслийг удирдаж хэрэгжүүллээ. Нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан ям болон сүрьеэгийн платформыг хөгжүүлэхэд юун дээр дээр илүү анхаарал хандуулах хэрэгтэй гэж бодож байна вэ?

Эрүүлмэндийн аюулгүй байдлын хариу арга хэмжээнд илрүүлэх, оношлох, эмчлэх багтай байдаг.

Миний хувьд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч биш судалгааны төсөл хэрэгжүүлж шинжлэх ухааны нотолгоо гаргана гэдэг амар ажил биш. Салбар бүрийн судлаачид нүүр тулсан ярилцлага хийж байж энэ ажлын ард гарна. Жайка дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч талбар дээр хамтран ажиллаж байгаа хүмүүсийн хүчин чармайлт чухал юм.

Сатоши Митарай, Япон улсын Сүрьеэгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Микобактерийн лавлагаа, судалгааны албаны дарга, профессор

1. Төслийн хүрээнд сүрьеэ, ямын оношилгооны шинэ дэвшилтэт аргуудыг нэвтрүүлсэн. Зоонзын өвчний хяналтылт, тандалтын платформын нэг чухал хэсэг нь лабораторийн оношилгоо гэж бодож байна. Төслийн хүрээнд нэвтрүүлсэн оношилгооны аргуудын тогтвортой байдлыг хангахад юуг анхаарах вэ ? Тогтвортой байдлыг хангаж авч явж чадахгүй тохиолдолд , платформд үзүүлэх сөрөг нөлөө юу байх вэ?

Хариулт Сатоши Митарай:

Сайхан асуулт байна. Түүхийг эргэж харахад маш идэвхтэй ажилласан цаг үеүд байлаа Өмнө 4000 тохиолдлыг илрүүлж байсан. Шинэ технологи байхгүй тохиолдолд халварлалтын түвшинд бууруулах боломжгүй. Сүрьеэгийн халдварлалтыг хэрхэн бууруулах вэ. Технологи бол нөхцөл байдлыг тодорхойлох бөгөөд зөвхөн технолог хэрэгжүүлсэн тохиолдолд халдварлалт буурахгүй юм.

Хэлэлцүүлгийн дүгнэлт:

Зоонозын өвчинтэй тэмцэх салбар хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах нэг эрүүл мэндийн үзэл баримтлалын хүрээнд зоонозын өвчинтэй тэмцэх цогц, үр дүнтэй цахим платформыг боловсруулахад янз бүрийн албан тушаалын гол оролцогч талуудтай хамтран ажиллах нь чухал юм.

Хэлэлцүүлгийн үеэр тавьсан тодорхой асуултуудад хариултаас дараах гол зүйлийг дурдъя.

1. Салбар хоорондын хамтын ажиллагаа: Зоонозын өвчлөлийг цогцоор нь шийдвэрлэхэд хүний эрүүл мэнд, малын эрүүл мэнд, байгаль орчны салбарын хамтын ажиллагаа чухал болохыг онцлон тэмдэглэсэн. Эрт илрүүлж, зохицуулалттай хариу арга хэмжээ авахын тулд салбар хоорондын өгөгдөл, мэдээллийг хуваалцахын ач тусыг онцлон тэмдэглэв.
2. Мэдээлэл хуваалцах: Цахим платформ дээрх өгөгдөл хуваалцах, нууцлал, мэдээлэл хамгаалах арга хэмжээнүүдтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх. Мэдээллийн солилцоог дэмжихийн зэрэгцээ нууц мэдээллийг хамгаалахын тулд өгөгдөл хуваалцах протоколууд байгаа эсэхийг шалгаарай.

2. 3.Хяналтын систем: Зоонозын өвчний тандалтын системийг бодит цагийн хяналт, эрт сэрэмжлүүлэх систем, хариу арга хэмжээний төлөвлөлтийг хөнгөвчлөхийн тулд нэгтгэх талаар ярилцана. Өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэхэд цаг тухайд нь мэдээлэл солилцохын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн.
 3. Чадавхийг бэхжүүлэх: Янз бүрийн салбар дахь оролцогч талуудад цахим платформыг ашиглах сургалт, чадавхийг бэхжүүлэх боломжуудыг судлах. Бүх хэрэглэгчид зоонозын өвчнийг мэдээлэх, хариу арга хэмжээ авахад платформыг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар ойлголттой болгох.
 4. Санал хүсэлтийн механизм: Оролцогч талууд цахим платформ дээр санал өгөх, сайжруулах санал гаргах, техникийн асуудлыг тайлагнах механизмыг бий болгох. Платформыг тасралтгүй оновчтой болгохын тулд нээлттэй харилцааны сувгийг дэмжинэ.
 5. Тогтвортой байдал: Цахим платформыг урт хугацаанд тогтвортой байлгах стратеги, түүний дотор засвар үйлчилгээ, шинэчлэлт, санхүүжилтийн механизмыг хэлэлцэнэ. Платформыг хамааралтай, ажиллагаатай байлгахын тулд тогтмол үнэлгээ, шинэчлэлт хийх төлөвлөгөөг тоймлох нь чухал.
- Эдгээрийг анхаарч үзээд оролцогч талуудын санал хүсэлтийг нэгтгэснээр зоонозын аюулын эсрэг мэдээлэл солилцох, хамтран ажиллах, үр дүнтэй хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх Зоонозын өвчинтэй тэмцэх цахим платформын оновчтой хувилбарыг бид бий болгож чадна.